



СОЁМБОМ ЭДЭЭ

ӨДӨР ТУТМЫН ЦАХИМ СОНИН

МОНГОЛ УЛСЫНХАА ТӨЛӨӨ ЗҮТГЭЭ!

190 /190/

2021.11.30

ЦАГ ҮЕ, ҮЙЛ ЯВДАЛ

Түүхэнд энэ өдөр

ОХУ-ЫН ЗХЖШ-ЫН ДАРГА ӨНӨӨДӨР МОНГОЛ УЛСАД АЛБАН ЁСНЫ АЙЛЧЛАЛ ХИЙЖ БАЙНА

ОХУ-ын ЗХЖШ-ын дарга, Батлан хамгаалахын нэгдүгээр орлогч сайд, армийн генерал В.В.Герасимов, ОХУ-ын ЗХЖШ-ын даргын туслах, хошууч генерал Сучков Вадим Юрьевич, Дорнод цэргийн тойргийн командлагчийн орлогч, дэслэгч генерал Носулев Михаил Яковлевич, ОХУ-ын ЗХЖШ-ын Оперативын Ерөнхий газрын орлогч дарга, хошууч генерал Москалик Ярослав Ярославович, ОХУ-ын БХЯ-ны Олон улсын цэргийн хамтын ажиллагааны Ерөнхий газрын орлогч дарга, хошууч генерал Липилин Алексей Анатольевич, ОХУ-ын ЗХЖШ-ын зөвлөх, хошууч генерал Троян Александр Георгиевич, ОХУ-ын Цэрэг-техникийн хамтын ажиллагааны Холбооны албаны 1 дүгээр орлогч дарга Бойцов Андрей Артурович тэргүүтэй албаны хүмүүс өнөөдөр манай улсад албан ёсны айлчлал хийж байна. Айлчлалын бүрэлдэхүүн 10:30 цагт "Чингис хаан" олон улсын нисэх буудалд газардсан бөгөөд Монголын талаас ЗХЖШ-ын дарга, дэслэгч генерал Д.Ганзориг, ЗХЖШ-ын орлогч дарга, бригадын генерал Ч.Цогтжаргал, БХЯ-ны ГХАГ-ын дарга, хурандаа Б.Бат-Эрдэнэ, ГХАГ-ын мэргэжилтэн, дэд хурандаа Г.Одбаяр нар утгаж авлаа. Үргэлжлүүлээд айлчлалын бүрэлдэхүүн ЗХЖШ-т ажиллах бөгөөд энэ үеэр ЗХЖШ-ын дарга, дэслэгч генерал Д.Ганзориг ОХУ-ын ЗХЖШ-ын дарга, Батлан хамгаалахын нэгдүгээр орлогч сайд, армийн генерал В.В.Герасимовтой хэлэлцээ хийнэ. Мөн Монгол Улсын Засгийн газрын гишүүн Батлан хамгаалахын сайд Г.Сайханбаяр төлөөлөгчдийг хүлээн авч уулзах юм. Түүнчлэн ОХУ-ын ЗХЖШ-ын дарга, Батлан хамгаалахын нэгдүгээр орлогч



сайд, армийн генерал В.В.Герасимов Монгол Улсын Ерөнхийлөгч, Зэвсэгт хүчний Ерөнхий командлагч У.Хүрэлсүхэд

бараалх, Зөвлөлт Холбоот Улсын маршал Г.К.Жуковын хөшөөнд хүндэтгэл үзүүлэх зэрэг арга хэмжээгээр үргэлжилнэ.

Түүний албан ёсны айлчлалын дэлгэрэнгүй мэдээллийг маргаашийн дугаараас хүлээн авч уншина уу.

1923 он.

“Монгол Ардын Засгийн Цэргийн явдлын яамны сайдын дүрэм” батлагдав.

ЦАГ АГААР

УЛААНБААТАР

ӨДӨР	ШӨНӨ
-9	-24

ӨМНӨД СУДАН

ӨДӨР	ШӨНӨ
39	24

ВАЛҮТЫН ХАНШ

ВАЛҮТ	АВАХ	ЗАРАХ
USD	2,852.0	2,854.0
EUR	3,275.0	3,285.0
CNY	445.80	449.80
RUB	38.50	40.00
JPY	24.65	25.23
KRW	2.38	2.46

ЗУРХАЙ

2021.11.30 ДАВАА ГАРАГ /БИЛГИЙН ТООЛЛЫН 26/

ӨВЛИЙН ТЭРГҮҮН ШАРАГЧИН ГАХАЙ САРЫН ДОЛООН УЛААН МЭНГЭТЭЙ ХАР МОРЬ ӨДӨР

Үс засуулбал:

ЖАРГАЛ ҮРГЭЛЖИД ИРНЭ

НАРАН УРГАХ, ШИНГЭХ:

08.19-17.02

Барилдлага:

Хүчин төгсөх

Шүтэн барилдлага:

Мунхрахуй

Суудал:

Мод

Энэ өдөр бар, нохой жилтнээ аливаа үйлийг хийхэд зэрэг сайн ба бич, тахиа жилтнээ сөрөг муу нөлөөтэй тул элдэв үйлд хянамгай хандаж, биеэ энхрийлүүштэй. Эл өдөр буян номын үйлийг эхлэх, дээдсээс халамж хүсэх, лам хувраг болох, багш шавьд барилдах, номын авшиг авах, шинэ гэр ба байр авах, гарагийг тахиж, тангараг тавих, гавар, байшингийн суурь тавихад сайн. Гэр бүрэх, хэрүүл тэмцэл хийх, улаа гаргах, хиншүү хярвас гаргахад муу.

Өдрийн сайн цаг нь хулгана, үхэр, туулай, морь, бич, тахиа болой. Хол газар яваар одогсод хойш мөрөө гаргавал зохистой. Үс шинээр үргээлгэх буюу засуулбал жаргал үргэлжид ирэх сайн.

“АХМАДЫН ЗӨВЛӨЛ”-ИЙНХӨН ЧУУЛАВ



Батлан хамгаалахын сайдын тушаалаар “Ахмад настанд эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ болон биеийн тамир, соёл урлаг, архивын үйлчилгээ үзүүлэх журам” батлагдсан юм. Энэ журмыг хэрэгжүүлэх зорилгоор Батлан хамгаалахын сайдын дэргэдэх Ахмадын зөвлөлөөс санаачлан Батлан хамгаалах, Зэвсэгт хүчний

нэгтгэл, анги, байгууллагын Ахмадын хороо, зөвлөлийн дарга нартай сургалтыг зохион байгуулав.

Сургалтыг нээж БХЯ-ны Ахмадын зөвлөлийн дарга, чөлөөнд байгаа хошууч генерал Д.Магсаржав хэлсэн үгэндээ “Бригадын генерал Г.Сайханбаяр Батлан хамгаалахын сайдаар томилогдсоноос хойш ахмад настны талаар 3 тушаал батлаад

байгаа бөгөөд түүний шийдвэрээр Ахмад настны өргөө баригдаж байгаа”-г онцолсон юм. Ингээд сургалтын салхийг хагалж БХЯ-ны Төрийн захиргааны удирдлагын газрын дарга, хурандаа С.Ванчинхүү Батлан хамгаалах бодлого, үйл ажиллагааг товч танилцуулаад дээр дурдсан журмын талаар дэлгэрэнгүй мэдээлэв. Түүний ярианаас ахмад

настанд үзүүлэх эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ анхаарал татаж байлаа. Тухайлбал, Цэргийн төв эмнэлэгт настан судлалыг хөгжүүлнэ, сэтгэл зүйн эмчийн үзлэгт ахмадуудыг хамруулна, үзлэгийн цагийг утсаар авч үйлчилнэ, өвчтөн хэвтүүлэх өдөр 3-аас доошгүй ахмадыг дараалал харгалзахгүй хэвтүүлнэ зэрэг хөнгөлөлттэй чихэнд таатай сонсогдож байв.

Эдгээр заалтуудын дагуу Цэргийн төв эмнэлэг өөрийн дотоод журамдаа тодотгол хийж хэрэгжүүлэх ажээ.

Мөн “Алдар” спорт хороо болон анги, байгууллагын спортын танхимд 7 хоногт 1 удаа 3-аас доошгүй цагийг ахмадуудад зориулна, Цэргийн чуулга, музейд зохиогдох урлаг, соёлын арга хэмжээнд хөнгөлөлттэй үйлчилнэ, Батлан хамгаалахын төв архивд салбарын ахмадуудын лавлагааг үнэ төлбөргүй гаргаж өгнө, “Соёмбо” сонин, “Дуулга” студиас ахмадуудын сурталчилгаанд мэргэжил, арга зүйн тусалцаа үзүүлнэ, “Бага баян”, “Найман шарга” цэргийн амралт, сувилалд жилд 1 удаа 7 хоног хөнгөлөлттэй амруулах зэрэг хууль эрх зүйн заалтыг тусгажээ.

(Үргэлжлэл нь II нүүрт)

МОНГОЛ УЛС ДАХЬ КОРОНАВИРУСИЙН МЭДЭЭ

НИЙТ БҮРТГЭГДСЭН
371,202 +190

ЭДГЭРСЭН
536,920

НАС БАРСАН
1,922 +8

ЦЭРГИЙН ТӨВ ЭМНЭЛЭГ

НИЙТ БАТЛАГДСАН
6510 +110

ХЭВТЭН ЭМЧЛҮҮЛЖ БУЙ
87

ЭДГЭРСЭН
6298

КОРОНАВИРУС ДЭЛХИЙ ДАХИНД

Тохиолдол
Нийт: 262,346,902

Эдгэрсэн
Нийт: 236,880,339

Нас барсан
Нийт: 5,224,152

цаг үе, үйл явдал

“АХМАДЫН ЗӨВЛӨЛ”-ИЙНХӨН ЧУУЛАВ



(Түрүүч нь I нүүрт)

Батлан хамгаалах, Зэвсэгт хүчний нэгтгэл, анги, байгууллагын Ахмадын хороо, зөвлөлийн дарга нартай явуулсан сургалтын үеэр ЗХЖШ-ын Ахмадын хорооны дарга, чөлөөнд байгаа хошууч генерал Д.Бадам “Судалгаа, мэдээний нэгдсэн загварчлал”-ыг танилцуулав. Ангиудын Ахмадын зөвлөлийн ажлыг хүндрүүлэхгүй байх үүднээс хоёрхон судалгаа хийж, жилдээ мөн тооны мэдээг дээд байгууллагадаа ирүүлж байхаар тогтжээ.

Ингээд төгсгөлд нь Монголын Ахмадын байгууллагаас хэрэгжүүлдэг “Ахмад настныг тэтгэвэрт бэлтгэх хөтөлбөр”-ийг үндэслэн боловсруулсан зөвлөмжийг ЗХЖШ-ын Хүний нөөцийн удирдлагын хэлтсийн дарга, хурандаа Н.Гантөмөр танилцуулав. Ажил хөдөлмөрийн идэвхтэй үеэс амьдралын дараагийн үед шилжихэд нийгэм, эдийн засаг, сэтгэл зүйн хувьд бэлтгэхэд юунд анхаарах талаар ярилаа. Тэтгэвэрт гарах хүмүүсийг 2-3 жилийн өмнөөс системтэй бэлтгэж эхлэх ажээ.

Үргэлжлүүлээд Батлан хамгаалах, Зэвсэгт хүчний нэгтгэл, анги, байгууллагын Ахмадын хороо, зөвлөлийн дарга нартай явуулсан сургалтын үеэр ахмадын хороо, зөвлөлийн дарга нар санал бодлоо хэллээ. Т.Сүхээ (337) “Ахмадуудын шагналын тодорхойлолтыг харьяаллын дагуу хороо, дүүргээр дамжуулж явуулдаг ч сураг тасардаг. Цэргийн хүмүүсийн хийсэн ажил, амжилтыг энгийн хүмүүс ойлгохгүйтэй

холбоотой байх”, Б.Лувсан “Цэргийн амралт, сувилалд ахмадуудыг анги байгууллагаар нь хуваариар, хөнгөлөлттэй үнээр амруулдаг болох”, Ж.Алтангэрэл (011) “Ахмад настны хуулийн дагуу Ахмадын санг байгуулж үзэмээр байна. Дан ганц хандив эсвэл татвараар ахмадуудын асуудлыг шийдвэрлэх боломжгүй”, Ё.Эрдэнэбилэг (013) “Ахмадуудыг бухимдуулдаг ганц асуудал бол тэтгэврийн зөрүү. Энэ талд Сайдын дэргэдэх Ахмадын зөвлөл дорвитой ажиллах хэрэгтэй”, С.Эрдэнэбаяр (232) “Цэргийн тэтгэвэрт гарсан хүмүүст эмэгтэй 55, эрэгтэй 60 нас хүрээгүй гээд ар гэрт нь оршуулгын тэтгэмж хүртэл олдохгүй эмгэнэлт байдалтай байна”, Батсүх (186) “Анги байгууллагын Ахмадын зөвлөлд ажиллах байр, цалин урамшуулал хүртэл алга. Анги, байгууллага Цагаан сар, Ахмад настны өдрөөр ахмадуудаа хүлээж авдаг. Бусад үед ахмадуудаа мартаж байгаа” гэж хэллээ.

Ахмадын зөвлөлийн дарга нарын санал шүүмжлэлийг Батлан хамгаалахын сайдад өгөх зөвлөмжид тусгах, ахмадын зөвлөлөө дэмжиж ажиллах талаар анги, байгууллагын захирагч, дарга нартай тулж ажиллах, ахмад настны шагналын тодорхойлолтыг ангиас Ахмадын хороогоор дамжуулан БХЯ, ЗХЖШ-т уламжилж байх, “Ахмад настанд эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ болон биеийн тамир, соёл, урлаг, архивын үйлчилгээ үзүүлэх журам”-ын хэрэгжилтийг зохион байгуулж ажиллана гэж чөлөөнд байгаа хошууч генерал Д.Магсаржав мэдэгдэв.

ЭНХИЙГ САХИУЛАГЧИД ЭЭЛЖ ХҮЛЭЭЛЦЛЭЭ



бөгөөд хариуцлагатай үүргийг залгамжлан авч буй XI ээлжийн цэргийн багийн бие бүрэлдэхүүний ажиллагааны өмнөх сургалт бэлтгэл болон ажиллагааны газар оронд ажил, үүргээ хүлээж авах явцад олж авсан туршлага сургамжууд нь та бүхний цаашдын үүрэг гүйцэтгэл, хувь хүний хөгжил, цэргийн хэргийн мэдлэг, дадлагад үнэтэй хувь нэмэр болно гэдэгт итгэл дүүрэн байна. Монгол цэргийн нэр хүндийг өндөрт өргөн, дэлхийн чихнээ дурсгаж байгаа цэнхэр дуулгат

БНӨСУ-д явагдаж буй НҮБ-ын мандаттай энхийг сахиулах ажиллагаанд үүрэг гүйцэтгэх Монгол Улсын Зэвсэгт хүчний Х, XI ээлжийн Мотобуудлагын батальонуудын ээлж хүлээлцэх ёслолын арга хэмжээ энэ сарын 26-ны өдөр “Хубилай” базад зохион байгуулагдлаа.

Монгол Улсын Зэвсэгт хүчний Х ээлжийн мотоуудлагын батальоны захирагч, хурандаа Д.Энхбаатар XI ээлжийн мотоуудлагын батальоны захирагч, хурандаа О.Заяатад НҮБ-ын далбаа болон Монгол Улсын төрийн далбаа, цэргийн багийн захирагчийн тамгыг албан ёсоор хүлээлгэж өгөв.

Цэргийн багуудын ээлж хүлээлцэх ёслолын арга хэмжээнд Юнити секторын командлагчийн орлогч, хурандаа Мухамед Кашип Наим, секторын хүчний штабын нэгжийн дарга нар болон албаны зочид төлөөлөгчид оролцсон юм.

Юнити секторын командлагчийн орлогч, хурандаа Мухамед Кашип Наим хэлсэн үгэндээ “Монголын батальон дан ганц цэргийн ажиллагаа болон техникийн мэдлэг чадварыг дээшлүүлэхэд хувь нэмрээ оруулаад зогсохгүй иргэн



цэргийн харилцааг бэхжүүлэх чиглэлээр шинэ ажлуудыг зохион байгуулсан нь орон нутгийн иргэдийн дунд НҮБ-д итгэх найдварыг төрүүлсэн.

НҮБ-ын үнэт зүйлийг сурталчлах, орон нутгийн иргэдийг хамгаалах болон Юнити Сектор амар тайван байдлыг тогтоохын тулд та бүхний гаргасан хичээл зүтгэлийг өндрөөр үнэлж байна” хэмээн онцлов.

Мотоуудлагын батальоны захирагч, хурандаа Д.Энхбаатар хэлсэн үгэндээ, “Эх орон, төр, ард түмэн, Зэвсэгт хүчнийхээ өмнө хүлээсэн хүндтэй

та бүхний энхийг сахиулах ариун үйлсэд тань амжил хүсье” хэмээв.

Харин XI ээлжийн мотоуудлагын батальоны захирагч, хурандаа О.Заяат “БНӨСУ-д үүсэж болох цаг төрийн тогтворгүй нөхцөл байдалд үүргээ амжилттай биелүүлсэн Х ээлжийн цэргийн багийн бие бүрэлдэхүүний хийж бүтээсэн бүхнийг түүчээлэн ололт амжилтыг бататган үүргээ амжилттай биелүүлэх болно” хэмээгээд Х ээлжийн мотоуудлагын батальоны бие бүрэлдэхүүний цаашдын ажил амьдралд нь сайн сайхан бүхнийг хүсэн ерөөлөө.

ЗАВСРЫН АУДИТЫН НЭЭЛТ БОЛЛОО



Үндэсний аудитын газраас жил бүр Төрийн аудитын тухай хууль болон Төсвийн тухай хуульд заасан цаглаврын дагуу санхүүгийн тайлангийн аудит хийдэг бөгөөд Батлан хамгаалахын сайдын энэ жилийн багцад хамаарах Төсвийн ерөнхийлөн захирагч, Засгийн газрын тусгай сан, мөн 2 төсвийн шууд захирагч, 4 төрийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газрын санхүүгийн тайлангийн завсрын аудитын нээлт Батлан хамгаалах яаманд боллоо.



Энэхүү завсрын аудитын нээлтэд Батлан хамгаалах яамны Төрийн нарийн бичгийн дарга, бригадын генерал Д.Ганхуяг, Үндэсний аудитын газрын Аудитын 4 дүгээр газрын дарга бөгөөд тэргүүлэх аудитор Я.Самбуунам болон аудитад хамрагдах Батлан хамгаалах яамны харьяа

байгууллага, Зэвсэгт хүчний зарим ангийн захирагч нар оролцсон юм. Энэ үеэр Үндэсний аудитын газраас санхүүгийн тайлангийн аудитад орох байгууллагуудад завсрын аудитын ойлголцлын санамж бичиг гардуулж, аудитаар ажиллах хоёр хуулийн этгээдийг танилцуулав. Мөн цар тахлын нөхцөл байдал, эдийн засгийн хямралыг

даван туулах төсвийн янз бүрийн зохицуулалт хийж буй төсвийн хүндрэлтэй байдалд аудитын байгууллага бусад байгууллагуудтай хамтран ажиллах, харилцан ойлголцолд хүрэх, санхүүгийн тайлангаа үнэн зөв тайлагнах зэрэг асуудлыг хөндсөн юм. Түүнчлэн энэ жилийн аудитын онцлогийн талаар харилцан ярилцаж нэгдсэн ойлголтод хүрлээ.

"ЭХ ОРОНЧ ҮЗЭЛ, ХҮМҮҮЖИЛ" СЭДВЭЭР ...

"Монгол цэргийн нэгдсэн холбоо" ТББ-аас ҮБХИС-ийн харьяа нийслэлийн ерөнхий боловсролын "Тэмүүжин Өрлөг", "Баянзүрх цогцолбор", нийслэлийн 53 дугаар дунд сургууль болон ҮБХИС-ийн сонсогч, оюутнуудын дунд "Эх оронч үзэл, хүмүүжил" сэдэвт сургалт, сурталчилгааны арга хэмжээг өчигдөр зохион байгууллаа. Тус арга хэмжээнд уригдан ирсэн хүндэт зочдын хувьд "Иргэдэд эх оронч үзэл, хүмүүжлийг төлөвшүүлэх нь", "Өсвөр үе-эх оронч үзэл", "Эх орон-100", "Хүүхэд залуучуудад, эх оронч үзэл, хүмүүжлийг төлөвшүүлэхэд "Тэмүүжин Өрлөг" дунд сургуулийн оролцоо" зэрэг сэдвийн хүрээнд лекц, илтгэл хэлэлцүүлэн сурагчдын сонирхсон асуултад хариулж, санал бодлоо солилцлоо. Энэ үеэр "Монгол цэргийн нэгдсэн холбоо" ТББ-ын Ажлын албаны зөвлөх, бэлтгэл бригадын генерал Д.Ганбаатар "Манай холбооноос хүүхэд, залуучуудад эх оронч үзэл, хандлага төлөвшүүлэх үндсэн зорилгынхоо хүрээнд дээрх арга хэмжээг зохион байгуулж байна. Үүний гол зорилго нь залуучуудад эх орон гэж хэр үнэ цэнтэй зүйл байдаг талаар ойлголтыг өгөх, ялангуяа манай орны Зэвсэгт хүчний ирээдүйн офицерууд болон бэлтгэгдэх "Тэмүүжин Өрлөг" сургуулийн сурагчдыг эх орноо хамгаалж хайрлах сэтгэлгээнд төлөвшүүлэх чухал ач холбогдолтой арга хэмжээ боллоо" гэв.



Дарга, ерөнхий редактор, хурандаа САНХМЯТАВЫН ТӨМӨРХҮЯГ

ЦАХИМ ХАЯГ
Батлан хамгаалах яам
Зэвсэгт хүчний Жанжин штаб

ЦАХИМ ХУУДАС
"Соёмбо" сонин
"Дуулга" студи

* Батлан хамгаалах, Зэвсэгт хүчний мэдээ мэдээллийг шуурхай нийтэлнэ.
* Батлан хамгаалах, Зэвсэгт хүчний нэгтгэл, анги, байгууллага хамт олны түүхт ой, тэмдэглэлт өдрүүдэд зориулсан тусгай дугаарыг бэлтгэнэ.
* Тус сонны мэдээллийг эх сурвалжийг дурьдан ашиглаж болно.

Хаяг: Улаанбаатар хот, Баянзүрх дүүрэг, Офицеруудын ордон
Индекс: 10018
Цахим шуудан:
Soymbom@mod.gov.mn
Утас: 70001029, 3412 (дотуур)